

ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

2020 оны 10 дугаар сарын 09-ны өдөр

Тендерийн нэр: **АГААРЫН ШУГАМЫН БҮРЭЭСТЭЙ УТАС /ТОДОТГОЛ/**

Тендерийн дугаар: **ХА-093/2020**

“УБЦТС” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос **“Агаарын шугамын бүрээстэй утас /тодотгол/”** нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг **2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 09 цаг 30 минутад** тендерийн нээлтийн өрөөнд нээнэ. /УБЦТС ТӨХК-н төв байрны 206 тоот/

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.
Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Захиалагчийн хаяг:

**Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-р хороо,
Чингисийн өргөн чөлөө-45.**

**УБЦТС ТӨХК-ийн төв байр. 206 тоот. Хангамж
үйлчилгээний алба Утас: 342420 +157, Факс: 976-341852
Цахим хаяг: www.tender.gov.mn**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн нэг жил буюу 2019 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх 2. Борлуулалтын орлого сүүлийн 1 жил буюу /2019 он/ санал болгож буй үнийн дүнтэй дүйцэхүйц 3. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /АС утас болон СИП кабель нийлүүлж байсан туршлагатай байх, гэрээний хуулбар, бараа хүлээлцсэн акт, протокол ирүүлнэ./ <p style="text-align: center;"><u>Нэмэлт шаардлага</u></p> <ol style="list-style-type: none"> 4. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга 5. Улсын бүртгэлийн гэрчилгээ 6. Үнийн саналыг маягтын дагуу ирүүлэх. Төсөвт өртөг /27 032 000 төгрөг / 7. Бараа нийлүүлэлтийн хуваарь /Гэрээний дагуу/ 8. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл заавал ирүүлнэ. 9. ШШГЕГ-ын тодорхойлолт 10. Татварын тодорхойлолт /тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байна./ 11. Гэрээний үнэ, хугацаанд хийж гүйцэтгэж, хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл ирүүлнэ. 12. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ. 13. Чанарын баталгаат хугацаа: 12 сар 14. Нийлүүлэх барааны зураг, үйлдвэрлэгчийн каталогийн эх хувийг ирүүлнэ. Каталог дээрээс санал болгож буй барааг ялган тодруулж ирүүлнэ. Гадаад хэл дээрх нийлүүлэх материалыг Монгол хэл рүү орчуулан ирүүлнэ. 15. Олон улсын чанарын стандартын шаардлага хангасан эсэхийг гэрчилэх гэрчилгээ, сертификатыг хавсарган ирүүлнэ. 16. Тендерийн баримт бичгийн 5,6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, тендерийн баримт бичгийн маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ. 17. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.

<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Харилцах утас: 976-11-342420+157, 158</p> <p>Байгууллагын хаяг: Хан-уул дүүрэг 3-р хороо Чингисийн өргөн чөлөө-45, "УБЦТС" ТӨХК-ийн төв байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2-р давхар, 206 тоот өрөө Огноо: 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Цаг: 09 цаг 00 минут</p> <p>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хан-уул дүүрэг 3-р хороо Чингисийн өргөн чөлөө-45, "УБЦТС" ТӨХК-ийн төв байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [2-р давхар, 206 тоот өрөө]</p> <p>Огноо: 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр</p> <p>Цаг: 09 цаг 30 минут</p>
<p>ТӨӨЗ 2.3</p>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. [Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотойгоор ТШӨХ-д заасан бүх баримт бичгийг жагсаан бичих] 2. ... 3.
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй ХА-093/2020“Агаарын шугамын бүрээстэй утас /тодотгол/”</p>

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. **Барааны тодорхойлолт: Агаарын шугамын бүрээстэй утас**
2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана.
3. **Баглаа, боодол:** Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.
4. **Бараа хүргэх газар:** УБЦТС ТӨХК-ийн Нисэх дэх агуулах
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Гэрээний дагуу

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

	Нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
	1	3	4	5	6	7	8
1	СИП2А 3*50+1*54,6	3000	м	УБЦТС ТӨХК-ийн Нисэх дэх агуулах	Гэрээний дагуу	Гэрээний дагуу	
2	СИПЗ 1*70	1000	м				
	НИЙТ	4000	м				

Жич: Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө нийлүүлэх бараа бүрээс 1 м загвар ирүүлнэ. Хэрэв ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.

Техникийн тодорхойлолт

1. АГААР МАНДЛЫН НӨЛӨӨЛӨЛД ТЭСВЭРТЭЙ ТУСГААРЛАХ БҮРЭЭС БҮХИЙ 0.4 КВ-ЫН СИП МАЯГИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ УТАСНЫ ХУДАЛДАН АВАЛТАД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

СИП (өөрийгөө даах, тусгаарлах бүрээстэй утас) маягийн цахилгаан дамжуулах шугамын утас нь УБЦТС ТӨХК-ийн ТШТ:ЕШН “Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл” техникийн шаардлагыг хангахын зэрэгцээ доор тусгасан тусгайлсан шаардлагыг давхар хангаж байх ёстой.

Энэхүү техникийн шаардлагаар УБЦТС ТӨХК-ийн цахилгаан түгээх сүлжээнд 2004 оноос хойш ашиглагдаж байгаа 1 кВ хүртлэх хүчдлийн СИП утсыг угсрах, ашиглах, засварлахад хэрэглэгдэх СИП-2А маркийн утасны хийц, үйлдвэрлэл, нийлүүлэлтэнд тавигдах шаардлагыг тогтоож өгнө. ОХУ-д үйлдвэрлэгдсэн СИП-2А маркийн утастай дүйцэхүйц техникийн шаардлагыг хангасан тоноглол байна.


Уг нийлүүлэх дамжуулагч утас нь дээрх үзүүлэлтүүдийг (**тусгаарлагын материал, дамжуулагчын хайлш, цаг уурын нөлөөлөлд тэсвэртэй байдал, удаан хугацаанд зөвшөөрөгдөх гүйдлийн хэмжээ зэргийг**) нотолсон үйлдвэрлэгчийн хэмжилт туршилт, мөн хөндлөнгийн үл хамаарах лабораторын баталгаат туршилтын бичиг заавал ирүүлсэн байна. Дээрх 2 туршилтын бичгийг хамтад нь хүчинтэйд тооцно.

СЕНЕЛЕС EN 50483 стандарт, ПАО Россети байгууллагаас ашиглаж болно гэсэн зөвшөөрлийн бичигтэй байвал давуу үзүүлэлт болно.

СИП- 2А утасны техникийн үзүүлэлтийн үндсэн шаардлагууд

ГОСТ-31946-2012 стандартын шаардлагад нийцсэн СИП-2А дамжуулагч утасны 0—ийн утас нь XLPE тусгаарлагатай, фазын 3 утас нь UV/XLPE тусгаарлагатай утасны багцын жинг 0-ийн утсаар дамжуулан авдаг байна.

Дамжуулагч утасны тусгаарлагч материал нь PVC, PE байхыг зөвшөөрөхгүй.

СИП-2А утасны бүтэц	
Хэвийн хүчдэл, кВ	0,4 кВ
Ажлын хамгийн их хүчдэл, кВ	1
Хэвийн давтамж, Гц	50
СИП утасны гүйдэл дамжуулах судлын стандарт хөндлөн огтлолууд	35, 50, 70, 95, 120, 150, 185, 240 (Захиалгын үед УБЦТС ХК-аас сонгон зааж өгнө)
СИП утасны нойлын судлын стандарт хөндлөн огтлолууд, мм ²	25, 35, 50, (54.6), 70, 95 (Захиалгын үед УБЦТС ТӨХК-аас сонгон зааж өгнө)
Нойлын болон гүйдэл дамжуулах жилүүдийн механик ачааны хуваарилалт	Гүйдэл дамжуулах судлуудад механик ачаалал үйлчлэхгүй байх
Богино залгааны үед хамгийн дээд халалтын зөвшөөрөгдөх температур, °С	250 ба түүнээс дээш байх

Нойлын гүйдэл дамжуулах жилийн хоорондох богино залгаа болох эрсдэл	Бага байх
Гүйдэл дамжуулах жил тусгаарлага	Гүйдэл дамжуулах жил XLPE /хөндлөн холбоост полиэтилен/ тусгаарлагатай байх
Нойлын гүйдэл дамжуулах жил тусгаарлагатай эсэх	Нойлын гүйдэл дамжуулах жил XLPE /хөндлөн холбоост полиэтилен/ тусгаарлагатай байх
Атмосферийн хэт хүчдэлийг тэсвэрлэх байдал	Өндөр байх
Барилгын хананд угсрах боломж	Боломжтой байх
Зэврэлтийг тэсвэрлэх байдал	Сайн байх
СИП утсыг алслалтын дунд холбох боломж	МЖРТ төрлийн зажимын тусламжтайгаар найдвартай, битүүмжлэгдэн холбогдох боломжтой байх
СИП утсыг татагч	РА-1500 төрлийн татагч байх
Угсралт	Анкерийн болон дүүжин арматур СИП утсыг нойлын нэг судлаар бэхлэхэд хөнгөн хялбар байх
Нарны хэт ягаан туяаны үйлчлэлд тэсвэртэй байх	СИП-ийн гадар бүрээс нарны хэт ягаан туяанд UV тэсвэртэй давхаргаар бүрэгдсэн байх ёстой

Хийцийн үндсэн шаардлага

ГОСТ-31946-2012 стандартын шаардлагад нийцсэн СИП-2А дамжуулагч утасны 0—ийн утас нь XLPE тусгаарлагатай, фазын 3 утас нь UV/XLPE тусгаарлагатай утасны багцын жинг 0-ийн утсаар дамжуулан авдаг байна.

СИП-2А маркийн утасны зөвшөөрөгдөх ачаалал

Фазын дамжуулагч болон нойлын дамжуулагчийн хөндлөн огтлол. мм ²	25° С үеийн зөвшөөрөгдөх хэвийн гүйдэл, А	1 секундын турш зөвшөөрөгдөх богино залгааны гүйдэл, кА
3x35+1x54.6	160	3.2
3x50+1x54,6	195	4,6
3x70+1x54,6	240	6,5

Дамжуулагчийн марк	Дамжуулагчийн хэвийн мм ² харгалзах тусгаарлагын зузаан, мм						
	16	25	35	50	70	95	120
СИП-2А	1.3	1.3	1.3	1.5	1.7	1.7	1.7

1. СИП-2 3x50+1x54.6 дамжуулагчийн үндсэн үзүүлэлтүүд :

- Гүйдэл дамжуулах судлын тоо – 4
- Гүйдэл дамжуулах судал - 3 ш 50 мм²
- Нойлын судал - 1 ш 54,6 мм²
- СИП-2 3x35+1x54,6 - 779 кг/км

- Гүйдэл дамжуулагчийн судлын тоо / нойлын судал-7 ш /7ш
- Гүйдэл дамжуулах судлын материал – хөнгөн цагаан
- Тусгаарлагчийн материал - зүймэл хэрээст полиэтилен тусгаарлага (XLPE)
- Бүрээсний материал - зүймэл хэрээст полиэтилен тусгаарлага (XLPE)
- Гадна талын диаметр (мм) 35
- Дамжуулагчийн актив эсэргүүцэл (ом/км) 1,54
- Зөвшөөрөгдөх нугалах радиус (мм) 350
- Агаарт байрлуулахад хамгийн их ачааллын гүйдэл (А) 195
- Богино залгааны үеийн зөвшөөрөгдөх гүйдэл (1сек турш) (кА) 4,6
- Хэвийн хүчдэл (кВ) - 1
- Утасны таталтын хүч – 16.6 кН
- Ашиглалтын температур -60 - +50 (°С)
- Ашиглалтын хугацаа 40 жил

Туршилтууд

Туршилтууд нь “ТШТ: ЕШН Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл”-ийн дагуу хийгдсэн байх ёстой.

Уг нийлүүлэх дамжуулагч утас нь дээрх үзүүлэлтүүдийг (**тусгаарлагын материал, дамжуулагчийн хайлш, цаг уурын нөлөөлөлд тэсвэртэй байдал, удаан хугацаанд зөвшөөрөгдөх гүйдлийн хэмжээ зэргийг**) нотолсон үйлдвэрлэгчийн хэмжилт туршилт, мөн хөндлөнгийн үл хамаарах лабораторын баталгаат туршилтын бичиг заавал ирүүлсэн байна. Дээрх 2 туршилтын бичгийг хамтад нь хүчинтэйд тооцно.

Тусгаарлагын материал, дамжуулагчийн хайлш, цаг уурын нөлөөлөлд тэсвэртэй байдал, удаан хугацаанд зөвшөөрөгдөх гүйдлийн хэмжээ зэргийг нотолсон үйлдвэрлэгчийн хэмжилт туршилт, мөн хөндлөнгийн үл хамаарах лабораторын баталгаат туршилтын бичиг аль нэг үзүүлэлт байхгүй тохиолдолд техникийн шаардлагыг хангасанд тооцохгүй.

Урьд өмнө Монгол орны нөхцөл орчинд ашиглагдаж байсан 5-аас багагүй жилийн эерэг туршлагатай байна.

Норматив ишлэл

Энэхүү техникийн шаардлагын тодорхойлолтод өөрөөр тусгаагүй бол доорх стандарт / тодорхойлолтын шаардлагыг заавал дагаж мөрдөнө.

Тодорхойлолт стандартын дугаар	Нэр
ГОСТ 52373-2005 Үндэсний стандарт	Өөрийгөө даах тусгаарлагч ба хамгалагчтай цахилгаан дамжуулах агаарын шугамын утас. Техникийн ерөнхий нөхцөл
ГОСТ 2990-78	Кабель дамжуулагч ба утас. Хүчдэлээр турших арга.
ГОСТ 3345-76	Кабель дамжуулагч ба утас. Тусгаарлагчийн эсэргүүцлийг тодорхойлох арга.

ГОСТ 7229-76	Кабель, дамжуулагч утас. Гүйдэл дамжуулагч судал ба дамжуулагчийн эсэргүүцлийг тодорхойлох арга
ГОСТ 10446-80 (ИСО 6892-84)	Цахилгаан утас. Суналтын /хэв гажиг/ туршилт
ГОСТ 12175-90 (МЭК 811-1-3-93)	Цахилгаан кабелийн тусгаарлага болон бүрхүүлийн материалын туршилтын үндсэн аргууд
ГОСТ 12177-79	Кабель, дамжуулагч ба утас. Бүтцийг шалгах аргууд. Нягтшил тогтоох аргууд. Агших болон ус даах туршилт.
ГОСТ 15845-80	Кабелийн бүтээгдэхүүн. Нэр томьёо, тодорхойлолт.
ГОСТ 18690-82	"Кабель, дамжуулагч утас ба кабелийн дагалдах хэрэгсэл. Барааны тэмдэглэгээ, сав баглаа боодол, тээвэрлэлт ба хадгалалт
ГОСТ 22483-77	Кабель, дамжуулагч ба утасны гүйдэл дамжуулах зэс болон хөнгөн цагаан судлууд. үндсэн параметрууд. Техникийн шаардлагууд
IEC 811-1-2-94	Цахилгааны кабелийн тусгаарлага ба бүрхүүлийн материалаыг турших арга үндсэн арга. Дулааны хуучраптын арга
IEC 60811-1-1-98	Цахилгааны болон шилэн кабелийн тусгаарлага ба бүрхүүлийн материалыг турших арга үндсэн арга. Зузаан ба гадна хэмжээг хэмжих Механик шинжийг тодорхойлох арга.
IEC 60811-2-1-2002	Цахилгааны болон шилэн кабелийн тусгаарлага ба бүрхүүлийн харимхай материалын туршилтын тусгай аргууд. Озоны үйлчлэлийг тэсвэрлэх, дулааны деформаци, тосны үйлчлэлийг тэсвэрлэх туршилтууд
IEC 60811-4-1-99	Цахилгааны кабелийн бүрхүүл ба полиэтилен /нийлэг/ ба полипропилен /энгийн хуванцар бүтэцтэй тусгаарлагч турших аргууд. Орчны нөхцөлд хүчдэлтэй нугаралтыг тэсвэрлэх туршилт. Хайшны хувирамтгай байдлыг тодорхойлох полиэтелин дэх хөө тортог/эсвэл минералын агууламжийг тодорхойлох

Ашиглалтын нөхцөл

ГОСТ 15150-69 “Машин, багаж хэрэгсэл болон бусад техник эд зүйлс. Цаг уурын янз бүрийн бүсэд зориулсан хийцүүд. Гадаад орчны цаг уурын нөлөөллийн хүчин зүйлээр ангилагдсан ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөлийн ангилал.” стандартаар тодорхойлогдсон ангилалаар УХЛ1 эсвэл УХЛ2 нөхцөлд суурилагдан ашиглагдахаар байх

ёстой. Орчны төрөл нь дээрх стандартын ангиллаар II төрөл буюу “үйлдвэрлэлийн” байх болно.

Тээвэрлэлт ба хадгалалт сав баглаа боодол

Нийлүүлэгдэх СИП утасны тээвэрлэлт, хадгалалт, сав баглаа боодол нь ГОСТ 18690-82 “Кабель, дамжуулагч, утас ба кабелийн дагалдах хэрэгсэл. Барааны тэмдэглэгээ, сав баглаа, боодол тээвэрлэлт ба хадгалалт” стандартын шаардлагуудыг хангасан байх ёстой.

Дээрх тоноглол нь “**ТШТ: ЕШН** Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл”-ийн суурь норматив баримт бичгүүд дээр заасан бүх заалтыг мөрдсөн байх ёстой.

1. Монгол Улсын загварын туршилтанд хамрагдсан, баталгаажуулсан гэрчилгээтэй байна. Баталгаажуулсан хугацаа: 2020 оны 02 сарын 01-ээс хойш байна.
2. Гүйдлийн трансформатор тус бүр нь хэмжилтийн протоколтой байна.
3. Гүйдлийн трансформатор нь дараах техникийн шаардлагуудыг хангахын зэрэгцээ олон улсын цахилгаан техникийн стандартуудад заасан шаардлагад нийцэж байх ёстой.

Стандартын дугаар	Стандартын нэр
IEC 60044-1 &-6	Instrument transformers – Part 1 Current transformers
IEC 60185	Current transformers
MNS4656	Гүйдлийн трансформатор, техникийн ерөнхий шаардлага
MNS 3019-99	Гүйдлийн трансформатор шалгах, арга, хэрэгсэл

4. Гүйдлийн трансформаторын хоёрдогч хэлхээг битүүмжлэн лацдах боломжтой, битүүмжлэл нь нэвт харагддаг байна.
5. Гүйдлийн трансформаторын ашиглах хугацаа нь 25-иас дээш жил байна.
6. Гүйдлийн трансформаторын ашиглалтын бичиг баримт дээр үйлдвэрлэгчийн нэр сериал дугаар, марк, анхдагч хоёрдогч хэвийн гүйдлийн утга, нарийвчлалын анги, хэвийн давтамж, нарийвчлалын зэрэгт харгалзах гаралтын утга, ажлын дээд хүчдэлийн утга, хөндийрүүлгийн түвшин, хөндийрүүлгийн зэрэг, богино хугацааны халалтын гүйдлийн утга болон динамик гүйдлийн утгуудыг тэмдэглэсэн байна.
7. Гүйдлийн трансформатор дээр үйлдвэрлэгчийн нэр, трансформаторын марк, трансформаци коэффициент, нарийвчлалын ангилал, анхдагч ба хоёрдогч ороомгийн эхлэл, төгсгөлийн тэмдэглэгээ, өөрийн хэрэгцээний чадлыг харах боломжтой байна.
8. Гүйдлийн трансформаторын пайз нь бат бөх хийцтэй, бичиглэл нь тод харагддаг, арилдаггүй, наалтан биш барласан буюу шивсэн байна.
9. Нарийвчлалын ангилал: ≤ 0.5 байна.
10. Гүйдлийн трансформатор нь бөөрөнхий болон хавтгай шинийн аль алинд суурилуулах боломжтой байна.
11. Гүйдлийн трансформаторууд нь бэхэлгээний суурьтай байна.
12. Нийлүүлэгдэх барааны хувьд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалт хангаж байгаа эсэхийг техникийн үзүүлэлт бүрээр нотолсон үйлдвэрийн баримт /техникийн өгөгдөл буюу паспорт/, холбоо

барих хаяг, майл хаягыг заавал ирүүлнэ.

13. Захиалагч талын тухайн бараа хариуцсан мэргэжилтэн, холбогдох хүмүүс бараа хүлээн авах явцад баримт бичгийн бүрдэл, гэрчилгээ зэрэг холбогдох бичиг баримттай тулгаж шалгана. Шаардлагатай бол туршилтанд хамруулж гарсан дүгнэлтэнд үндэслэнэ.
14. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд барааг буцаах ба тус барааг сольж өгнө. Үүнтэй холбоотой гарах зардлыг захиалагч тал хариуцахгүй.

Хийцийн үндсэн шаардлага

СИП-2А утасны гүйдэл дамжуулах материал хөнгөн цагаан байна. СИП-2А утсыг зөвхөн нойлын судлаар тулгуурт өлгөдөг байна.

СИП-2А маркийн утасны зөвшөөрөгдөх ачаалал

Фазын дамжуулагч болон нойлын дамжуулагчийн хөндлөн огтлол. мм ²	25° С үеийн зөвшөөрөгдөх хэвийн гүйдэл, А	1 секундын турш зөвшөөрөгдөх богино залгааны гүйдэл, кА
3x16+1x25	100	1.5
3x35+1x54.6	160	3.2
3x50+1x50	195	4,6
3x50+1x54,6	195	4,6
3x50+1x70	195	4,6
3x70+1x54,6	240	6,5
3x70+1x70	240	6,5
3x70+1x95	240	6,5
3x95+1x70	300	8,8
3x95+1x95	300	8,8
3x120+1x95	340	7,2

1. АГААР МАНДЛЫН НӨЛӨӨЛӨЛД ТЭСВЭРТЭЙ ТУСГААРЛАХ БҮРЭЭС БҮХИЙ 6-10 КВ-ЫН СИП-3 МАЯГИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ УТАСНЫ ХУДАЛДАН АВАЛТАД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

6-10 кВ-ын Агаарын шугамд хэрэглэх СИП-3 маягийн (өөрийгөө даах, тусгаарлах бүрээстэй утас) цахилгаан дамжуулах шугамын утас нь УБЦТС ТӨХК-ийн ТШТ:ЕШН “Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл”-ийн шаардлагууд болон ГОСТ Р 52373 стандартын шаардлагыг хангаж байх ёстой.

Гүйдэл дамжуулах судлын үзүүлэлтүүд

Хөндлөн огтлол, мм ²	Судал дахь утасны тоо, ш	Судлын гадаад диаметр, мм		1км дамжуулагчийн цахилгаан эсэргүүцэл, Ом	Судлын бат бөх, кН
		Хамгийн бага	Хамгийн их		
35	7	6.7	7.1	0.986 багагүй	10.3 багагүй
50	7	7.9	8.4	0.720 багагүй	14.2
70	7	9.5	10.0	0.493 багагүй	16.6

Тусгаарлах бүрээс нь Полиэтилен материалаар хийсэн байх ба 10-20кВ-ын хэвийн хүчдэлд тусгаарлагын зузаан нь 2.3мм байна.

СИП утасны угсралтыг гадна орчны температур -20°С байх үед хийх боломжтой байх ёстой.

Хөндлөн огтлол, мм ²	Зөвшөөрөгдөх ачааллын гүйдэл, А /ихгүй/		Богино залгааны тэсвэрлэх гүйдэл, кА /ихгүй/
	20 кВ хүртэл	35 кВ	
35	200	220	3.0
50	245	270	4.3
70	310	340	6.0

Нийлүүлэгч нь санал болгож буй (СИП-2, СИП-3) төрөл бүрээс загвар ирүүлнэ.

Туршилтууд

Туршилтууд нь “ТШТ: ЕШН Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл”-ийн дагуу хийгдсэн байх ёстой.

... 22. Хэрэглэгдэж буй бүх материалууд нь гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу холбогдох материалын стандартаар үйлдвэрийн хяналт хэмжилт, туршилтыг хийх ба эсвэл УБЦТС ХК-ийн зүгээс ажлын явцад шаардсаны дагуу хяналт хэмжилт, туршилтыг хийнэ. Үйлдвэрлэгч нь тухайн тоног төхөөрөмжид хамаарах стандартуудаар тодорхойлогдсон бүх хяналт хэмжилт, туршилтыг хийнэ. Үүнээс гадна үйлдвэрлэгчийн өөрийн гаргасан чанарын хяналтын стандартуудад тодорхойлогдсон бүх хяналт хэмжилт, туршилтыг хийнэ.

УБЦТС ХК нь зарим эсвэл бүгд хэмжилт туршилтын явцад биечлэн байлцах эрхтэй бөгөөд Гэрээлэгч нь тухайн хэмжилт, туршилтыг хийхээс 14 хоногийн өмнө УБЦТС ХК-д мэдэгдэх үүрэгтэй. УБЦТС ХК-ийн оролцох туршилтын ажлын зардлын талаар гэрээний нөхцөл зөвшилцөх шатанд тохиролцсон байх ба гэрээний үнэд багтсан байна.

Хэрэв гэрээгээр нийлүүлж буй бараа бүтээгдхүүн ба/эсвэл түүний бүрэлдэхүүн хэсэг, материал нь энэхүү техникийн шаардлагыг хангахгүй бол цаашдын нэмэлт хэмжилт туршилт хийх шаардлагатай.

Энэ тохиолдолд дахин хэмжилт туршилттай холбогдон гарах нэмэлт зардлыг нийлүүлэгч гэрээлэгч тал бүрэн хариуцна.

Ашиглалтын нөхцөл

ГОСТ 15150-69 “Машин, багаж хэрэгсэл болон бусад техник эд зүйлс. Цаг уурын янз бүрийн бүсэд зориулсан хийцүүд. Гадаад орчны цаг уурын нөлөөллийн хүчин зүйлээр ангилагдсан ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөлийн ангилал.” стандартаар тодорхойлогдсон ангилалаар УХЛ1 эсвэл УХЛ2 нөхцөлд суурилагдан ашиглагдахаар байх ёстой. Орчны төрөл нь дээрх стандартын ангиллаар II төрөл буюу “үйлдвэрлэлийн” байх болно.

Тээвэрлэлт ба хадгалалт сав баглаа боодол

Нийлүүлэгдэх СИП утасны тээвэрлэлт, хадгалалт, сав баглаа боодол нь ГОСТ 18690-82 “Кабель, дамжуулагч, утас ба кабелийн дагалдах хэрэгсэл. Барааны тэмдэглэгээ, сав баглаа, боодол тээвэрлэлт ба хадгалалт” стандартын шаардлагуудыг хангасан байх ёстой.

Дээрх тоноглол нь “**ТШТ: ЕШН** Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл”-ийн суурь норматив баримт бичгүүд дээр заасан бүх заалтыг мөрдсөн байх ёстой.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. Олон улсын болон дотоодын эрх бүхий байгууллагаар заавал шалгалт туршилт хийлгэсэн байна. Барааг захиалагчийн төлөөлөгч болох СБХ-ийн нярав, ХҮА-ны мэргэжилтэн, ТБЗХ-ийн хариуцсан инженерт хүлээлгэж өгнө. Барааг туршуулаагүй тохиолдолд захиалагч уг барааг хүлээж авахгүй байх эрхтэй.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын хугацаа **12 сар** байна.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[тоо]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²
- 9.1. Алданги оногдуулах хувь: **Хоногт гэрээний үнийн дүнгийн 0,1 %**
- Алдангийн нийт дүн: **Гэрээний үнийн дүнгийн 10 %**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]